

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг . НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургуулийн оюутны зөвлөл /цаашид ХДСОЗ гэх/ нь энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Монгол Улсын Үндсэн Хууль , Монгол Улсын боловсролын хууль , ХДС-н оюутны холбогдолтой дүрэм , журам , зарчмуудын хүрээнд гишүүд болон нийт оюутанд үйлчлэх ТББ /төрийн бус байгууллага/ мөн .

1.2 Тус байгууллагын оноосон нэрийг Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэг дээд сургуулийн оюутны зөвлөл гэнэ .

1.3 ХДСОЗ нь Дархан-Уул аймгийн Дархан сум 12-р баг Хүмүүнлэгийн дээд сургуулийн 3 давхарт 305 тоотод байрлана.

1.4 ХДСОЗ нь тэмдэг, бэлэгдэл, данс, албан бичиг хэвлэмэл хуудас , тамгатай байна.

Хоёр . ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

2.1 ХДСОЗ-н эрхэм зорилго нь ХДС-н нийт оюутнуудын эрх ашгийг хамгаалж , тэдний сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлэн, өөрийгөө хөгжүүлэх , мэдлэг эзэмшихэд нь тэдний дуу хоолой болон ажиллахад оршино.

2.2 ХДСОЗ нь ХДС-ийн захиргаатай хамтран ажиллаж , ХДС-ийн нийт оюутны эрх ашиг , хүсэл эрмэлзлийг илэрхийлэн хамгаалж , тэдний төлөөлөл болон ажиллана.

2.3 ХДСОЗ нь үйл ажиллагаандаа шударга ёс , тэгш эрхийг эрхэмлэн , оюутнуудын эв нэгдлийг хангах зарчмыг баримтлана.

2.4 ХДСОЗ нь хувь хүний хөгжлийг дэмжих , хөгжүүлэх чиглэлээр олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.5 ХДСОЗ нь тус сургуулийн захиргаанаас гарч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд оюутнуудыг хамруулж , зохих мэдээллээр хангана.

2.6 ХДСОЗ нь ХДС-ийн оюутны сонирхлын клубүүдыг дэмжин клубүүдийн нэгдсэн зөвлөлд батламж олгож элсүүлэн авч , боломжит нөхцөлүүдээр хамтарч ажиллана.

2.7 ХДСОЗ нь тус сургуулийн оюутнуудын ашиг сонирхлын нэгдмэл байр сууринаас илэрхийлнэ.

2.8 ХДСОЗ нь үйл ажиллагааныхаа дагуу улс эх орон, өөрийн нийгэмд ач тустай нөлөө үзүүлэхийг ямагт хичээн ажиллана.

2.9 ХДСОЗ нь ХДС-ийн боловсролын системийг боловсронгуй болгох , чанарын үр ашгийг дээшлүүлэхийн төлөө ажиллана.

Гурав. ХДСОЗ-НЫ БҮТЭЦ

3.1 ХДСОЗ нь дараах салбар зөвлөлүүд , гүйцэтгэх албатай байна.

3.1.1 Удирдах зөвлөл

3.1.2 Хяналтын зөвлөл

3.1.3 Маркетингийн зөвлөл

3.1.4 Хүний нөөцийн алба

- 3.1.5 Сургалт судалгааны алба
- 3.1.6 Урлаг спортын алба
- 3.1.7 Дотуур байрны нэгдсэн зөвлөл
- 3.2 ХДСОЗ нь ХДС-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд өөрийн төлөөлөлтэй байна.
- 3.3 ХДСОЗ-ийн эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл байна.
- 3.4 ХДСОЗ-ийн зөвлөх багш нь Оюутны хөгжил хариуцсан мэргэжилтэн байна.

Дөрөв. САЛБАР НЭГЖҮҮДИЙН БҮТЭЦ, ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Удирдах зөвлөлийн бүтэц

4.2 ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн дарга нь ХДСОЗ –ийн Тэргүүн байна.

4.2.1 Удирдах зөвлөл нь доорхи гишүүдээс бүрдэнэ.

- Тэргүүн
- Дэд тэргүүн
- Ерөнхий нарийн бичгийн дарга
- Нарийн бичиг
- Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн дарга
- Дотуур байрны оюутны зөвлөл

4.3 Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тэдний бүрэн эрхийн хугацаа:

4.3.1 ХДСОЗ-ийн Тэргүүн , дэд тэргүүн , Хяналтын зөвлөлийн дарга нар ХДСОЗ –ийн ээлжит чуулганаар дараагийн ээлжит чуулган хүртэл 2 жилийн хугацаанд бүрэн эрхтэй ажиллана.

4.3.2 ХДСОЗ-ийн үйл ажиллагааны чиглэл болон ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах эрхтэй .

4.3.3 ХДСОЗ –ийн дотоод дүрэм журмыг өөрчлөн байгуулах , татан буулгах эрхтэй.

4.3.4 ХДСОЗ-ийн гүйцэтгэх хорооны бүтэц, зохион байгуулалт , үйл ажиллагааг хянах эрхтэй .

4.3.5 Удирдах зөвлөл болон гишүүдийн эрхийг түтгэлзүүлэх эрхтэй .

4.3.6 Удирдах зөвлөл нь ХДСОЗ-г төлөөлөн үйл ажиллагаанд оролцох эрхтэй .

4.3.7 Удирдах зөвлөлийн гишүүдээс өөрийн бүрэн эрхийн хугацаа дуусаагүй нөхцөлд оюутны статусаа алдвал бусад тэргүүлэгч гишүүд нь бүрэн эрхээ хадгалж үлдэнэ. /Тодорхой шалтгааны улмаас оюутан статусаа түр алдсан тэргүүлэгч гишүүн эргэн оюутан статустай болох нөхцөл бололцоотой бол эргэн үүрэгт ажлаа хүлээж автал орны үүрэг гүйцэтгэгч ажиллуулж болно./

4.3.8 Удирдах зөвлөл нь ХДСОЗ болон сургуулийг бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах .

ТАВ . ХДСОЗ-ЫН ЧУУЛГАН

5.1 ХДСОЗ-ийн дээд байгууллага нь ХДСОЗ-ийн чуулган мөн .

5.2 ХДСОЗ-ийн ээлжит чуулган 2 жилд нэг удаа хуралдана.

5.3 ХДСОЗ-ийн Удирдах зөвлөл чуулганы комиссыг томилно.

5.4 ХДСОЗ-ийн Тэргүүн ээлжит чуулганыг даргална.

5.5 ХДСОЗ-ийн чуулганы бүрэн эрх:

5.5.1 ХДСОЗ-ийн Тэргүүн , Дэд тэргүүнийг сонгоно.

5.5.2 ХДСОЗ-ийн дүрэм, бүтэц, зохион байгуулалтанд нэмэлт өөрчлөлт оруулж батлана.

5.6 Чуулганы комисс хэлэлцэх асуудал болон дэгийг ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлөөс тогтоож чуулганы товоос 14-21 хоногийн өмнө нийтэд зарлана.

5.7 Чуулганы бэлтгэл ажлыг чуулганы комисс хариуцна.

5.8 Чуулганы төлөөлөгчдийн ирц нь 51 хувиас дээш тохиолдолд уг чуулганыг хүчинтэйд тооцно.

5.9 Чуулганаар хэлэлцэх асуудлыг олонхийн буюу чуулганд ирсэн төлөөлөгчдийн 51 хувийн саналаар шийдвэрлэнэ.

5.10 ХДСОЗ-ийн зөвлөх багш болон ХДСОЗ-ийн гишүүд санал өгөх эрхтэй оролцоно.

5.11 ХДСОЗ-ийн Тэргүүн, Дэд тэргүүнд нэр дэвших оюутан нь дараах шаардлагыг хангасан байна.

5.11.1 ХДС-ийн 1 ба 2-р курсийн оюутан байх

5.11.2 Сурлагын ерөнхий голч дүн 3,4-өөс дээш байх

5.11.3 ХДС-ийн нийт оюутны дуу хоолой, тэдний төлөөлөл болон ажиллах чадвартай

5.11.4 Бусдыг манлайлах, удирдан зохион байгуулах чадвартай

5.11.5 Оюутан залуучуудын хөгжлийн асуудлаар тодорхой ойлголт мэдлэгтэй энэ чиглэлээр цаашид ажиллах сонирхолтой.

5.11.6 Судалгаа эрдэм шинжилгээний ажил хийх чадвартай.

5.11.7 Нийгэмд тустай олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулж байсан туршлагатай

5.11.8 Бичгийн болон ярианы өндөр чадвартай

5.12 ХДСОЗ-ийн Тэргүүн, дэд тэргүүнд нэр дэвших оюутан нь дараах материалыг бүрдүүлнэ.

5.12.1 ХДС-н Оюутны зөвлөлийн тэргүүн, Дэд тэргүүнд нэр дэвшиж буй өөрийн хүсэлтийг илэрхийлсэн гараар бичсэн өргөдөл

5.12.2 Мөрийн хөтөлбөр \ 2 жилийн хугацаанд хийх ажлын стратеги төлөвлөгөө\

5.12.3 Дүнгийн хуулбар

5.12.4 3x4 хэмжээтэй чээж зураг

5.12.5 Нэр дэвшигчийн анкет

5.12.6 Өөрийн давуу талыг тодорхойлох бусад нэмэлт материалууд

5.13 Ээлжит бус чуулган:

5.13.1 ХДСОЗ-ийн ээлжит бус чуулганыг доорхи тохиолдолд шаардлагатай гэж үзвэл ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн 90 болон түүнээс дээш хувьтай гишүүн зөвшөөрсн тохиолдолд зарлана.

5.13.1.1 ХДС-ийн нийт ангийн дарга нарын 3\2 нь ээлжит бус чуулганыг хуралдуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд

5.13.2 ХДСОЗ-ийн Тэргүүн, дэд тэргүүн ХДС-н оюутны статусаа бүрэн алдсан тохиолдолд зарлана.

ЗУРГАА . ХДСОЗ-Н ТЭХГҮҮН, ДЭД ТЭРГҮҮН , ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРИЙН БҮРЭН ЭРХ , ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1 ХДСОЗ-ийн тэргүүн

- ХДСОЗ-ийн Тэргүүн ХДС-н оюутан байна
- ХДСОЗ-ийн Тэргүүнийг ээлжит чуулганаар нэр дэвшүүлэн сонгох бөгөөд чуулганаар хэлэлцэн улируулан сонгож болно.
- ХДСОЗ-ийн Тэргүүн нь ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн хурлыг даргална.
- ХДСОЗ-ийн Тэргүүн ХДС-н Удирдах зөвлөлийн гишүүн байна.
- ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн гаргасан ХДСОЗ-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталгаажуулна.

- Ажлын холбогдолтой шийдвэр гаргана.
- ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн олгосон эрх хэмжээний хүрээнд ХДСОЗ-г төлөөлж өмч хөрөнгийг захиран зарцуулна.

6.2 Дэд тэргүүн

- ХДСОЗ-ийн ХДСОЗ-ийн Дэд Тэргүүн ХДС-н оюутан байна
- ХДСОЗ-ийн Дэд Тэргүүнийг ээлжит чуулганаар нэр дэвшүүлэн сонгох бөгөөд чуулганаар хэлэлцэн улируулан сонгож болно.
- ХДСОЗ-ийн Тэргүүний эзгүйд түүний шийдвэрээр зарим бүрэн эрхийг нь Тэргүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн үед бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.
- ХДСОЗ-ийн бодлого стратегийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд гар бие оролцоно.
- ХДСОЗ-ийн бүх гишүүдийн хурлыг даргална
- Дэд тэргүүн нь Тэргүүний болон Удирдах зөвлөлийн захирамж зааврыг биелүүлэх үүрэгтэй
- Дэд тэргүүн нь гүйцэтгэх хорооны 4 салбар , сургуулийн оюутны зөвлөл Оюутны клубийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагааг хариуцаж ажиллана.

6.3 Ерөнхий нарийн бичгийн дарга

- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нь ХДС-н оюутан байна
- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн даргыг ээлжит чуулганаар сонгогдсон тэргүүн, дэд тэргүүн хэлэлцэж сонгоно.
- Ерөнхий нарийн бичгийн дарга нь ХДСОЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.
- ХДСОЗ-ийн эд хөрөнгө болон санхүүгийн захиран зарцуулалтад хяналт тавина.
- Ерөнхий нарийн бичгийн дарга нь ХДСОЗ-ийн гүйцэтгэх хорооны дарга байна
- Ерөнхий нарийн бичгийн даргын бусад эрх , үүрэг хариуцлагын хэмжээ хязгаарыг ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлөөс тогтоож болно.
- ХДСОЗ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга нь ХДСОЗ-ийн дотоод бодлогыг хэрэгжүүлэгч байна.
- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга бичиг хэрэг архивыг бүрдүүлнэ.
- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нь Тэргүүн , Дэд тэргүүний захирамж, зааврыг биелүүлэх үүрэгтэй .

ДОЛОО. ХДСОЗ-Н ГИШҮҮНЧЛЭЛ

7.1 ХДСОЗ-ийн нийт гишүүдийг үндсэн болон түр гэж ангилна.

7.2 ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийг оролцуулан 30 хүртлэх гишүүдтэй байна.

7.3 ХДСОЗ-ийн гишүүн нь 3.0 болон түүнээс дээш голчтой олон нийтийн үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзлэлтэй байна.

7.4 ХДСОЗ-ийн элсэгч нь 1-2 сарын хугацаанд түр гишүүний статустай байна.

7.5 Түр гишүүн нь ХДСОЗ-д 1-2 сарын хугацаанд ажилласаны дараа Удирдах зөвлөлийн шалгаруулалтанд оролцож тодорхой сэдвийн хүрээнд Эссэ бичин шаадлага хангасан тохиолдолд үндсэн гишүүний эрхтэй болно.

7.6 ХДСОЗ-ийн шаардлагатай тохиолдолд түр хугацааны сайн дурын гишүүдийг элсүүлэн авч болно.

7.7 Тодорхой үндэслэлийн дагуу Удирдах зөвлөлийн хуралдаан нь гишүүдийн эрхийг түтгэлзүүлж болно.

7.8 ХДСОЗ-ийн гишүүдийн эрх

- ХДСОЗ-ийн нийтлэг эрх ашгийн хүрээнд үйл ажиллагаанд нь оролцох эрхтэй

- Өөрийн саналаар ХДСОЗ-ийн гишүүдийн статусаас татгалзаж болно
- ХДСОЗ-ийн үйл ажиллагаа , бодлогод нийцэхүйц саналыг оруулж дэмжүүлэх эрхтэй

7.9 ХДСОЗ-ийн гишүүний үүрэг

- Эрх бүхий субъектээс даалгасан үүрэг даалгаварыг биелүүлнэ
- ХДСОЗ-ийн зорилгод нийцэх үйл ажиллагааг явуулна
- Захирах захирагдах журмыг баримтлана.
- ХДСОЗ-ийн хурлын дэгийг баримтлана.

7.10 ХДСОЗ-ийн гишүүн гүйцэтгэх ажилтаны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд , аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол түүнээс үүсэх хариуцлагыг ХДСОЗ хүлээхгүй

НАЙМ.ХДСОЗ-Н ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

8.1 ХДСОЗ-ийн хяналтын байгууллага нь Хяналтын зөвлөл мөн

8.2 ХДСОЗ-ийн хяналтын зөвлөл ХДС-ийн төлөөлөл ХДСОЗ-ийн гишүүн бус гурваас таван оюутны бүрэлдэхүүнтэй байна

8.3 ХДСОЗ-ийн Хяналтын зөвлөлийн гишүүд болон дарга түүний эрх үүрэг , ажлын чиглэл, бүтэц бүрэлдэхүүнийг ХДС-ийн чуулганаар батлана.

8.4 Хяналтын зөвлөл нь ХДСОЗ-ийн хуралдаанд санал оруулах эрхтэй.

8.5 Хяналтын зөвлөл нь ХДСОЗ-с зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

8.6 Хяналтын зөвлөл нь ХДСОЗ-ийн санхүүгийг болон үйл ажиллагааны тайланг улирал тутамд шаардан гаргуулах эрхтэй.

8.7 Хяналтын зөвлөл нь ХДСОЗ-ийн аливаа дутагдлыг залруулах үүрэгтэй.

ЕС. ХДСОЗ-Н САНХҮҮ

9.1 ХДСОЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон төсвийг Тэргүүний зөвшөөрлөөр , Дэд тэргүүний хяналттайгаар ерөнхий нарийн бичгийн дарга захиран зарцуулна.

9.2 ХДСОЗ-ийн орлого дараах эх үүсвэрээр бүрдэж болно.

- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого.
- Сургуулийн захиргаанаас үзүүлэх дэмжлэг
- Зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын болон байгууллагын төсвөөс олсон хөрөнгө
- Санаачлан байгуулагчдын дэм хандив
- Дотоод гадаад дэмжигч байгууллагын дэм хандив
- Бусад эх үүсвэр

9.3 ХДСОЗ-ийн зарлага

- ХДСОЗ нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна
- ХДСОЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн , үндсэн гишүүн , тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно
- ХДСОЗ нь Ерөнхийлөгч , Улсын их хурал болон иргэдийн төлөөлөгчдийн сонгуульд нам эсвэл нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандив өргөхийг хориглоно.

9.4 ХДСОЗ-ийн тайлан:

- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нь зохих журмын дагуу сарын тайлан тэнцлийг гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Дэд тэргүүний хяналттайгаар Тэргүүнд өгнө.
- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нь салбар нэгжүүдээс улирлын тайланг нэгтгэж авна.
- ХДСОЗ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нь тайлангаа гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ
 1. Байгууллагын хаяг
 2. Үйл ажиллагааны тухай товч мэдээлэл
 3. Жилийн орлого зарлагыг дор дурьдсан ангиллаар
 - Хандивийн
 - Дүрмийн зорилгоо хэргэжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаа
 - Өвлүүлсэн эд хөрөнгө

ХДСОЗ-ийн санхүүгийн тайлангаа хичээлийн жилийн улирал тутамд зөвлөх багшид тайлагнана.

АРАВ . ХДСОЗ-Г ТАТАН БУУЛГАХ

10.1 ХДСОЗ-ийг дараах үндэслэлээр ХДСОЗ-ийн Удирдах зөвлөл татан буулгана

- Цаашид үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болсон
- Дүрэмд заасан зорилгоо биелүүлсэн
- Зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөх болсон

10.2 ХДСОЗ нь татан буугдах тохиолдолд зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй байгууллагад шилжүүлэх буюу хэрэв тийм байгууллага байхгүй бол зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

10.3 ХДСОЗ нь татан буугдсан тухай шийдвэрийг 21 хоногийн дотор нийтэд мэдээллэнэ.